



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 13

Сангийндалай

Бэлчээрийн менежментийн 2025 оны
төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 52.2, 52.4 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Сумын “Бэлчээрийн менежментийн 2025 оны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж хэрэгжилтийг тооцон хагас, бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Засаг дарга (С.Мөнхбаатар), Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн (И. Дүрзээ) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ш. СҮХБАЯР

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны сарын өдрийн ээлжит 2 дугаар
хуралдааны дугаар тогтоолын дүгээр хавс

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН БЭЛЧЭЭРИЙН
МЕНЕЖМЕНТИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Агуулга	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт		Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр	2025	
				Суурь он	Суурь түвшин		Хүрэх түвшин	Төсөв
1.	Өрхүүдийг өвөлжөө хаваржааны дэргэд нөөц бэлчээртэй болгох	Нийт малчин өрхийн 4% нь нөөц бэлчээртэй болсон байна.	хувь	2024	3,6%	Малчид өөрсдийн хөрөнгөөр	4%	
2.	Малын бэлчээрийн талбайг гүн өрмийн худгаар усжуулах	Шинээр гаргасан худгийн тоо	тоо	2024	5	Аймгийн ХО, Төсөл хөтөлбөр, Малчид	2	
3.	Энгийн уурхайн худгийг сэргээн засварлах	Сэргээн засварласан худгийн тоо	тоо	2024	6		2	
4.	Бэлчээрийг нөхөн сэргээх өтгөрүүлэх арга технологийг малчдад сурталчлан таниулах	Сургалтад хамрагдсан малчны тоо	тоо	2024	0	Малчид Малын тоо толгойн албан татвар	50	10,0 сая
5.	Бэлчээрийг цөлжилтөөс хамгаалах, элсний нүүдлийг тогтоон барих, мод олон наст ургамал тарихад дэмжлэг үзүүлэх	Мод тарьсан иргэдийн тоо	тоо	2024	25.	Өрхийн болон Төсөл хөтөлбөр	25	
6.	Бэлчээрийг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх, хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Техникийн үр дүн 85%-аас дээш байна.	хувь	2024	85-87%	Улсын төсөв Малын тоо толгойн албан татвар Айл өрх	85%	Малын тоо толгойн албан татвараас зарцуулна.
7.	Өвөлжөө хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх ажлыг үргэлжлүүлэх	Малчин өрх бүр өвөлжөө хаваржааны	тоо	2024	18	Малчид өөрсдийн хөрөнгөөр	10	

		доорх газраа өмчилсөн тоо						
8.	Сумын хэмжээнд бэлчээр хадлангийн төлөв байдлын үнэлгээг хийж тухайн жилийн цаг агаарын нөхцөл бэлчээрийн гарцыг үнэлж бэлчээрийн даацын хүрэлцээ ургамлын гарцын талаар дүгнэлт гаргах, бэлчээрийн мониторинг хийх	26 цэгт мониторинг хийх	тоо	2024	26	ЗДТГ	26	
9.	Хөдөө аж ахуйн газар болон өвөлжөө хаваржааны доорхи газрыг кадастрын зургаар баталгаажуулж мэдээллийн санд оруулан ажлыг үргэлжлүүлэх	Хийсэн кадастрын тоо	тоо	2024	18	Малчид өөрсдийн хөрөнгөөр	10	
10.	Өөрийн аймаг болон бусад аймаг сумын нутаг руу нүүдэл хийх шаардлага гарвал харъяалах сум багийн удирдлагуудтай уулзаж гэрээ байгуулах	Гэрээ хийсэн тоо	тоо	2024	1	ЗДТГ	1	
11.	Сум дундын отрын бэлчээрийг хамгаалах	Отрын бэлчээрийг 6-р сарын 01-11-р сарын 01 хүртэлх хугацаанд чөлөөлсөн байх	тоо	2024	1	Малын тоо толгойн албан татвар	1	
12.	Тэжээлийн ургамал тариалах, өвс тэжээлийн нөөцийн бүрдүүлэлт	Тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлсэн тоо	тоо	2024	14	Малчид өөрсдийн хөрөнгө, Малын тоо толгойн албан татвар	30	
13.	Бэлчээр газар тариалангийн үйлдвэрлэлттэй холбоотой төсөл хөтөлбөрийг сумын хэмжээнд зохион байгуулах	Уур амьсгалын өөрчлөлтөнд тэсвэртэй орон нутаг төсөлтэй уялдуулан малын тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлэх	тоо	2024	1	Төсөл хөтөлбөр	1	Төсөл, хөтөлбөр